



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Дүүргийн харьяа байгууллагууд,
Засаг даргын Тамгын газрын бүтэц,
ажлын байрны жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а" дахь заалт, 29.2, 29.3, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 66 дугаар зүйлийн 66.1.7 дах заалт, Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1331 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн удирдлагыг дор дурьдсанаар баталсугай.

- 1.1. Засаг дарга /1 туслах ажилтантай/
- 1.2. Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
- 1.3. Засаг даргын орлогч, дэд бүтэц, байгаль экологийн төсөл хөтөлбөрүүдийн удирдагч
- 1.4. Засаг даргын зөвлөх

2. Тамгын газрын бүтцийг дор дурьдсанаар баталсугай.

- 2.1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
- 2.2. Санхүү, төрийн сангийн хэлтэс
- 2.3. Нийгмийн хөгжлийн хэлтэс
- 2.4. Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс
- 2.5. Хөдөө аж ахуйн тасаг
- 2.6. Цэргийн штаб
- 2.7. 1 дүгээр хороо
- 2.8. 2 дугаар хороо

3. Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, хороодын ажлын албаны бүтэц, ажлын байрны жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах харьяа байгууллагуудыг ажиллуулахаар тогтоосугай.

- 4.1. Ахмадын хороо
- 4.2. Боловсролын хэлтэс
- 4.3. Биеийн тамир, спортын хороо
- 4.4. Газар зохион байгуулалтын алба

1123020034

- 4.5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
- 4.6. Дотоод аудитын алба
- 4.7. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв
- 4.8. Мэргэжлийн хяналтын тасаг
- 4.9. Нийгмийн даатгалын хэлтэс
- 4.10. Онцгой байдлын хэлтэс
- 4.11. Соёлын ордон
- 4.12. Татварын хэлтэс
- 4.13. Улсын Бүртгэлийн хэлтэс
- 4.14. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
- 4.15. Худалдан авах ажиллагааны алба
- 4.16. Цагдаагийн хэлтэс
- 4.17. Эрүүл мэндийн төв
- 4.18. Мал эмнэлгийн тасаг
- 4.19. Дүүргийн статистик хариуцсан мэргэжилтэн

5. Төрийн захиргааны албан хаагчдын болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний албан хаагчдын бүтэц, ажлын байрны жагсаалтыг тогтоон баталж, мөрдүүлэхийг Засаг даргын Тамгын газар /Л.Санжийжамц/-т зөвшөөрсүгэй.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/251, 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/75 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА *С. Эрдэнэбаяр* С.ЭРДЭНЭБАЯР



